



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/464

Хэрлэн сум

Соёл урлагийн ажилтны баярт зориулж
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёл урлагийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу соёл, урлагийн ажилтны дунд зохион байгуулагдах урлаг, спортын бэсрэг наадмыг зохион байгуулахад шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Монгол үндэсний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх" зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ